

АСРАМЖИЙН ГАЗРААС ГЭР БҮЛД ЭРГЭН НЭГТГЭХ ҮЙЛЧИЛГЭЭ: АСУУДАЛ, СОРИЛТ

*Г. Шүрэнцэцэг
Доктор оюутан*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

gerelsrencecege@gmail.com

*С. Туяа
Доктор (Ph. D.), дэд профессор*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

s.tuya@must.edu.mn

***Хураангуй:** Асрамжийн төвд амьдарч буй хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх нь нэн чухал байна. Улсын хэмжээний 17 байгууллагын 21 төвд 1000 орчим хүүхдүүд амьдарч байгаа бөгөөд тэдний дөрөвний нэг нь эцэг эхгүй бүтэн өнчин, бусад хүүхдүүдийн хувьд эцэг эх, асран хамгаалагчийн хэн нэгэн байгаа юм. Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг зайлшгүй хэрэгжүүлэх, хүүхдийг эцэг эхтэйгээ хамт амьдрах боломжтой болгохын тулд гэр бүлийн эрсдэлт хүчин зүйлийг арилгаж, хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх, үйлчилгээг өргөжүүлэх судалгааг ч олон улс орнуудад хийсээр байна. Манай хүүхдийн асрамжийн төвүүд хуульд зааснаар эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, нийгмийн халамж, хуулийн үйлчилгээг хүргэн ажиллаж байгаа боловч гэр бүлд нь эргэн нэгтгэх чухал үйлчилгээ бараг хэрэгжихгүй байгаагаас олон хүүхэд төвдөө насанд хүртлээ удаан хугацаанд амьдарч байгаа төдийгүй эцэг эх ч үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхгүй, мартсан байгаа нь том асуудал дагуулж байгаа билээ. Энэхүү өгүүлэлд асрамжийн газраас хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйл явц, ач холбогдол болон боломжит шийдлээс судлан дүгнэлт гаргахыг зорьлоо.*

***Түлхүүр үг:** Эргэн нэгтгэх, үйлчилгээ, хүүхэд хамгаалал*

УДИРТГАЛ

Хүүхдийн эрхийн конвенци болон бусад эрхийн баримт бичиг, үндсэн хуулийн агуулгаар хүүхэд бүр гэр бүлдээ, эцэг эхдээ хайрлуулан амьдрах эрхтэй. Тэд гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрал, аливаа хөдөлмөрийн мөлжлөгөөс

ангид байх эрхтэй гэдгийг ч бүгд хүлээн зөвшөөрч хамгаалахыг хүсдэг. Өнөөдөр улсын хэмжээнд 17 байгууллагын 21 төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар, Дархан-Уул аймаг, Дорнод аймаг, Өвөрхангай аймгийн Хархорин хотод тус тус хүүхдийн

төвүүд ажиллаж, энэ оны байдлаар 974 хүүхэд амьдарч байгаагаас 204 нь бүтэн өнчин, 303 нь хагас өнчин, 443 нь гэр бүлтэй, 24 нь олдмол хүүхэд байна.

Эцэг эх, асран хамгаалагч нь амьд сэрүүн боловч үл хайхрах, сэтгэцийн өвчин эмгэгтэй, хорих ялтай, хөдөлмөрийн чадвараа алдсан, хүчирхийлэл зэрэг төрөл бүрийн шалтгаанаас хүүхэд гэртээ очих боломжгүй тусгаарлагдсан байдаг. Хүүхэд хамгааллын тогтолцоонд гэр бүлд түшиглэсэн хувилбарт үйлчилгээ, асралт гэр бүлийн үйлчилгээг хүргэж байгаа туршлага ч бий.

Хүүхдийн зөрчигдөж байгаа эрхийг хамгаалах, асран халамжлах үүргийг гүйцэтгэх зорилгоор 7 хоногоос 1.6 жилийн хугацаанд асрамжийн байгууллагад байршуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээг хүргэж байна. Эдгээр үйлчилгээг Улаанбаатар хотын хэмжээнд хувийн болон төрийн өмчийн төрөлжсөн асрамжийн газар хүргэж байгаа бөгөөд тэднийг аюулгүй орчинд асарч өсгөх, сурч боловсроход нь туслах, хүмүүжүүлж төлөвшүүлэх, бие даасан амьдралд бэлтгэх үүргийг төрүүлсэн эцэг эхийн оронд хүлээж байна.

Түр хамгаалах байр нь аюултай нөхцөл байдалд байгаа хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан хамгаалах үйлчилгээг Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд

тавигдах нийтлэг шаардлагын дагуу хүргэж байх үүрэгтэй. Гэр бүлийн нөхцөл байдал сайжирч, аюулын зэрэг буурч, хүчирхийлэл дарамтад дахин өртөхгүй эерэг өөрчлөлт гарсны дараа хүүхдийг гэр бүлд нь буцаах, эргэн нэгтгэх шаардлагатай.

Нөгөөтэйгүүр гэр бүлийн орчин нөхцлөөс хол, бүрмөсөн хөндийрч насанд хүртлээ асрамжийн газарт амьдарч байгаа ялангуяа бага насны хүүхдүүд эцэг эхээ санах, бэтгэрэх, улмаар сэтгэлийн хүнд шархтай хэвээр өсөж, эцэг эхээ гомдон буруутгах, үл ойшоох, голох, хүүхэд ахуй цагтаа хаягдаж байсан шигээ тэднийг орхих, харилцаа холбоо тасрах гэх мэт хувь хүний ээдрээтэй, хүнд хэцүү амьдралын тойрогт эргээд орох нь маш их байна (Ц.Амаржаргал, 2025). Өөрөөр хэлбэл бага ахуй наснаасаа хэвийн амьдралд өсөөгүй, гэр бүлийн үнэ цэн, эцэг эхийн хайр халамжийг мэдрэхгүй байх нь тэдний ирээдүйн амьдралд асар их хор уршигтай юм. Иймээс хүүхдийг гэр бүлд нь буцаан нэгтгэх үйлчилгээний хэрэгцээ, хэрхэн хэрэгжүүлэх арга зүй, технологийн шаардлага их байгаа билээ. Судалгаанд хоёрдогч эх сурвалжийн шинжилгээ болон харьцуулсан шинжилгээний арга зүйг ашиглав.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг гэр бүлээсээ дайжиж

гудамжинд амьдарч байгаа, хүний наймааны золиос болсны улмаас өөр газар оронд амьдарч байгаа, асрамжийн газарт амьдарч буй, түр хамгаалах үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүдэд хүргэдэг юм. 2004 онд Wulczyn Гэр бүлд нь эргэн нэгтгэх (reunification) хэмээх ойлголтыг “аюулгүй бөгөөд тогвортой” байдал, “гэр бүлээс гадуур асрамжийн газарт байгаа хүүхдийг биологийн буюу төрөлх орон гэрт нь буцаах үйл явц” (Child Welfare Information Gateway, 2011) хэмээн тодорхойлжээ. Гэр бүлд амжилттай нэгтгэх гэдэг нь хүүхдийг асрамжийн тогтолцооноос гаргаж биологийн гэр бүлд дахин амьдруулах, байнгын болон урт хугацааны туршид сайн сайхан байдлыг чухалчилдаг үйл явц билээ. Өөрөөр хэлбэл амжилттай нэгдэх гэдэг нь аюулгүй байдлыг бий болгож өгөөд гэр бүлийн зүгээс хүүхдийн хэрэгцээг хангах, хүүхэд анх гэрээсээ дайжихад хүргэсэн эрсдэлд дахин өртөхгүй байх нөхцөл боломжийг бий болгох, чадваржуулах үйл явц юм. Гэр бүлийн тогтвортой, аюулгүй байдал, сайн сайхан байдал нь тухайн хүүхдийн сайн сайхан байдлын үндсэн тулгуур байдаг (Salus, 2003). Хэдийгээр хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний зорилт боловч төрсөн гэр бүлээс нь удаан хугацаагаар хөндийрүүлэх нь тэдний ирээдүйн амьдралд ч мөн сөрөг нөлөөтэйг харуулсан судалгаа олон байна (Wulczyn, 2004).

Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээний хэрэгцээ, хэрэгжүүлэх загварын үндсийг хэд хэдэн онолд тулгуурлан авч үзэх боломжтой. Үүнд:

- ① Хэрэгцээний шатлалын онол
- ② Гэр бүлийн системийн онол
- ③ Нийгмийн экологийн онол
- ④ Нийгмийн суралцахуйн онол
- ⑤ Үйлчлүүлэгч төв онол гм.

Нийгмийн ажлын онол практикт өргөн хэрэглэгдэж, хувь хүн, гэр бүлийн нийгмийн асуудал, хэрэгцээг тайлбарладаг А.Маслоу – ийн онолд хүний зан үйл нь хэрэгцээ шаардлагаас үүдэлтэй хэмээн онцолсон бөгөөд “хэрэгцээ нь доод шатандаа физиологиос эхлээд өөрийгөө бодитой болгох хүртэл хэд хэдэн шатлалд хуваагддаг, нэг хэрэгцээний илрэл нь нөгөө илүү давамгайлсан хэрэгцээг урьдчилж хангаснаас хамаарна” (Maslow, 1973) хэмээн үзсэн байдаг. Энэхүү онол нь гэр бүл эргэн нэгдэх чухал хүрээг харахад тусалдаг. Тухайлбал гэр бүлийг эргэн нэгтгэхэд хамгийн их хэрэгцээтэй байгаа үндсэн хоол хүнс, орон байрны цаашлаад “дээд түвшний” хэрэгцээг хүртэл харах боломжийг олгодог. Rabin, Rosenbaum, Sens нар (1982) ч гэр бүлд сэтгэл зүй, зан үйлийг тусламж дэмжлэгийг хүргэхээс өмнө тэдний хэрэгцээг хангахын чухлыг хүлээн зөвшөөрч байжээ (Rabin, 1982).

Гэр бүлийн системийн онолын үзэл баримтлалд Bertalanffy, Anderson, Carter (Elaine Walton,

1995) нар гэр бүлийн орчны зохион байгуулалт, бүтэц, хил хязгаар, тэнцвэрт байдал, харилцан үйлчлэл, хэсгүүдийн хамаарал, зөрчилдөөн, нөөцийн оролт, гаралт гэх мэт ойлголтыг тодорхойлж, гэр бүлийн терапи, стратегийн эмчилгээ, гэр бүл төвтэй нийгмийн ажлын практикийг санал болгосоор байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нийгмээс суралцахуйн онолын хувьд гэр бүлийн үйл явц, хүүхдийн зан төлөвийг тайлбарлахдаа ур чадварыг чухалчилдаг юм. Харин үйлчлүүлэгч төвт онолд үзсэнээр гэр бүлд үйлчилгээг амжилттай хүргэж, хөндлөнгийн оролцоог хэрэгжүүлэхийн тулд нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйчийн альтруист хандлага чухал юм. Энэхүү шаардлага нь үйлчлүүлэгч төвт үзэл баримтлалын үндэс суурь болох ба үйлчлүүлэгчийн идэвхитэй оролцоо, хариуцлагатай байдлыг бий болгоно. Өөрөөр хэлбэл үйлчлүүлэгчийн асуудлыг сонсох, өөрийгөө таньж мэдэхэд нь туслах нь гэр бүлийг эргэн нэгтгэх харилцааг үр дүнтэй болгоно.

Манай улсын хувьд MNS 5258 2017 стандартыг мөрдлөг болгон, магадлан итгэмжлэгдсэн байгууллага энэхүү үйл ажиллагаа эрхэлдэг ба хүүхдүүдийн төвд ирж буй шалтгааныг үзвэл:

- ① Архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэл
- ② Эцэг эхийн үл хайхрал

- ③ Орон гэргүй байдал
- ④ Хорих байгууллагаас суллагдсан ч хүүхдээ хайхрахгүй, эрхэлсэн ажилгүй байх
- ⑤ Бэлгийн хүчирхийлэлийн хохирогч байна.

Асрамжийн газарт амьдарч буй хүүхдийн хувьд хувийн анхаарал халамж дутмаг, сэтгэл зүйн хөгжилд сөргөөр нөлөөлөх эрсдэл, нийгэмших үйл явцад хүндрэл үүсэх гэх мэт олон асуудлыг ч дагуулдаг билээ.

Гэр бүлийн хүчирхийлэл, салалт, эдийн засгийн хямрал, архидалт, ядуурал зэрэг нийгмийн асуудалтай гэр бүл хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байгаагаас хүүхэд зохиомол өнчрөлд автаж байгааг олон кейсээс харж болно.

Дээр дурьдсанчлан энэ оны байдлаар 974 хүүхэд асрамжийн төвүүдэд амьдарч байгаагаас 746 хүүхэд эцэг эх, хамаатан садан, асран хамгаалагчтай байна. Үйл ажиллагаа явуулж буй зарим асрамжийн төвөөс гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээний хүрээнд ар гэртэй нь холбоо тогтоох, төвийн үйл ажиллагаанд эцэг эхийг татан оролцуулах, гэр бүл хамтад нь үйлчилгээг хүргэх ажлыг хэрэгжүүлж байгаа боловч хичнээн хүүхэд гэр бүлдээ эргэн очиж байгаа, гэр бүлдээ эргэн нэгдсний дараах үнэлгээ, үр дүнг судалсан нэгдсэн үзүүлэлт хангалтгүй байна. Асрамжийн төвд амьдарч буй хүүхдүүд эцэг эхтэйгээ ч хамт үйлчилгээ авах тохиолдол их

байдаг. Зарим төвүүдэд хүүхдийг хүлээн авсан цагаас эхлэн боломжтой бол гэр бүлтэй холбоо тогтоож эргэн нэгтгэх хүртэл сүүлийн үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлдэг ч хуулийн бүрэн зохицуулалтгүй, зарим эцэг эх байх эрхийг түдгэлзүүлсэн зэргээс тэд төвдөө үргэлжлүүлэн амьдрахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсдэг байна.

Өнөөгийн байдлаар төв эрүүл мэнд нөхөн үржихүй, боловсролын, сэтгэл зүйн, нийгмийн халамжийн, хуулийн, гэр бүлд эргэн нэгтгэх гэсэн нийт зургаан төрлийн үйлчилгээг хүүхдүүдэд хүргэн ажилладаг. Ихэнхдээ эхний таван төрлийн үйлчилгээг тасралтгүй, илүү хүртээмжтэй, чанартайгаар хүргэхэд анхаарч ажилладаг ч зарим нь үр дүнтэй байхад зарим нь үр дүн тааруу байх ч тохиолдол практикт их байна.

Гэр бүл, эцэг эхийн зөрчилдөөн маргаантай асуудлаас шалтгаалж хүүхдийг эхний 3 сар гэр бүлийн гишүүдтэй уулзах уулзалт төлөвлөдөггүй. Учир нь эцэг эх, асран хамгаалагч сэтгэл зүйн асуудалтай, бухимдалтай байдлаасаа хүүхдэд сэтгэл зүйн гэмтэл учруулах, гомдоох, сэтгэлийн шарх өгөх, амь насанд нь ч эрсдэл үүсдэг учир уулзалтыг доод тал нь 6 сараас хойш төлөвлөх нь тохиромжтой аж. Зарим нөхцөлд ийм уулзалт 1-2 жилээр хойшлох нь ч байдаг.

Хүүхдүүдийг хүлээн авсан цагаас эхлэн төвд дасган зохицуулах, байршуулах гэдэг том асуудлаас бүх үйлчилгээ эхэлж байна. Учир нь хүүхэд өөрийн сайн дураар ирэх нь ховор, эрсдэлтэй нөхцөл байдлын улмаас гэр бүлээсээ түр тусгаарлагдаж байгаагаа ойлгож, хүлээн зөвшөөрөх чухал байдаг. Ирж буй хүүхдүүд тэр бүр эрүүл саруул бие бялдартай ирэх нь ховор, ямар нэгэн суурь өвчлөлтэй байна. Ялангуяа идэж ууж байгаа хоол хүнсний буруу хэрэглээ, ахуй соёлын зөв дадал сураагүйн улмаас шүдний өвчлөл ихтэй, улмаар үе мөч, сонсгол, харааны бэрхшээл болон хөгжлийн хоцрогдол, оюуны бэрхшээлтэй байгааг төвийн багш, нийгмийн ажилтнууд онцолжээ.

Бага насандаа ямар өвчин тусч байсан, цусны бүлэг, хаана, ямар эмчилгээ хийлгэсэн зэрэг өвчний түүхгүй учраас эмнэлэгт багагүй бэрхшээлтэй тулгардаг ба хүүхдийг хүлээн авсан анхан шатны хамгаалах байр мэдээлэл бүртгэлийг бүрэн хийж дараагийн шатны байгууллага руу шилжүүлэх шаардлагатай болдог байна. Хүүхдийн гэр бүлтэй ажиллах үед эцэг эхийн зүгээс ирэх сөрөг хандлага, бүртгэлтэй хаяг, байршилдаа амьдардаггүй, холбогдох утас солигдох, засаг захиргааны анхан шатны нэгжийн холбон зуучлал мэдээлэл дутуу зэргээс хамтын ажиллагаанд ахиц гарахгүй, үйлчилгээ удаашрах нь нэн тулгамдсан бэрхшээл юм.

Шийдэл: Туршлага ба интервенци

Хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйл явц дараах үндсэн зарчмыг баримтлах шаардлагатай.

1. Хүүхдийн ашиг сонирхолд нийцүүлэх
2. Гэр бүлийн нөхцөл байдлыг нарийвчлан үнэлэх
3. Алхамт харилцан ойлголцол бүхий эргэн нэгтгэх үйл явцыг хэрэгжүүлэх
4. Дэмжлэг, хяналтыг үргэлжилсэн тасралтгүй байдлаар хийх гэх мэт.

Асрамжийн төвөөс эцэг эхийн хандлагыг өөрчлөх, хариуцлагаа ойлгох, хүүхдээ эргүүлэн авах эрмэлзлийг бий болгох үе шаттай үйлчилгээг эхэлж, амжилт олсон сайн туршлага манай хувийн салбарын зарим төвд байна. Эдгээр төвийн үйлчилгээний арга зүйг, сайн туршлагыг хүүхэд хамгааллын тогтолцоонд нэвтрүүлэх, эргэн нэгтгэх үйлчилгээг тэлэх шаардлагатай. Тухайлбал нэгэнт эцэг эх, хүүхэд нэг гэр бүл болон хамтдаа амьдрах тохиолдолд төвөөс дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх / хүүхдийн төв /;
- Холбогдох хороо дүүргийн хамтарсан багаар нөхцөл байдлын үнэлгээ хийлгэх;
- Хүүхдийг дасан зохицох хугацаагаар гэрт нь амьдруулах;
- Эцэг эхийг сэтгэл зүйн зөвөлгөөнд хамруулах;

- Гэр бүлд материаллаг тусламж үзүүлэх;
- Гэр бүлд 7 хоногт 1 удаа зочлох;
- Гэр бүлд зочлолтын хугацааг холдуулах;
- Гэр бүлийг баяр ёслолоор төвийнхөө арга хэмжээ, өдөрлөгт урих гэх мэт.

Гэсэн хэдий ч Berenice Rushovich нарын судалгаагаар (Berenice Rushovich, 2021) гэр бүлийн хүчирхийллийн улмаас эцэг эхийнхээ гэрээс гарсан нийт хүүхдийн тал буюу 49 хувь нь эцэг эхтэйгээ эргэн амьдарч байгаа ч 20-40 хувь нь таван жилийн дотор асрамж халамжийн газарт буцаж ирдэг болох нь батлагджээ. Гэр бүлд нь нэгтгэх үйлчилгээний загвар, хөтөлбөр, арга зүйг бий болгон хэрэгжүүлж байгаа олон улсын туршлага их аж. Энэ үйлчилгээнд олон бэрхшээл тулгардаг бөгөөд тэдний дотоод чадавхи, тэвчээр, тэсвэрийг бий болгоход дэмжлэг үзүүлэх өмгөөлөгч, дасгалжуулагчийн тусламж хэрэгтэйг хүлээн зөвшөөрч, “*Success Coach post-reunification program*” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлдэг аж. Амжилтийн дасгалжуулагчид нь хүүхдийг эргэн нэгтгэсний дараа гэр бүлийн тогтвортой байдал, бусад хамгаалах хүчин зүйлсийг бий болгоход тусалдаг гэжээ. Энэ хөтөлбөр үйлчилгээг 2015 онд Катавад мөн бусад орон нутагт өргөжүүлж судалгааг эхлүүлсэн байна.

АНУ, Англи, Австрали, Канад зэрэг орны хүүхэд хамгааллын бодлого нь хүүхдийг эцэг эхтэй нь эргэн нэгтгэх чиглэлийг ихээхэн анхаарч байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, эрсдэлд орсон хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь хамгийн эхний зорилт мөн ч гэсэн удаан хугацааны туршид гэр бүлээс нь тусгаарлах, хөндийрүүлж салгах нь тэдний ирээдүйд асар их сөрөг нөлөөтэйг баталсан (Wulczyn, Family Reunification. , 2004) гэдгийг дээр дурьдсан билээ. Эдгээрийн үр дүнд сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд асрамжийн газарт байгаа хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх нэн тэргүүний зорилт хэмээн тооцогдох болжээ.

АНУ-д асрамжийн төвд амьдардаг хүүхдүүдээс жил бүр 270.000 орчим нь төвөөс гарч дийлэнхи нь төрсөн эцэг эхдээ буцаж очих хүсэлтэй байгаагаа байнга илэрхийлдэг бол (Powers, 2007) хожим нь насанд хүрсний дараа ч гэр бүлтэйгээ холбогдох хүсэл нь хэвээрээ төрсөн эцэг эх, хамаатан саднаа хайдаг (Child Welfare Information Gateway, 2011) байна.

Нөгөө талаас харвал гэр бүлд эргэн нэгдэж буй хүүхдүүдийн гуравны нэг нь хүчирхийлэлд өртөж асрамжийн газартаа дахин очдог болохыг олон улсын судалгаанаас харж болно. Энэ байдал нь бага насны хүүхдийн хурдацтай хөгжиж буй тархинд маш хортой нөлөөтэй. A.LaBrenz, Rowena Fong нарын

судалгааны үр дүнгээс харвал эмч, халамжийн байгууллага, ажилтнууд гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг нэн тэргүүнд тавих ёстойг (A. LaBrenz a, 2019) үйлчилгээнд анхаарч үнэлгээг хийх хэрэгтэй. Иймээс гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг зөвхөн хүүхдэд хүргэх нь хангалтгүй бөгөөд гэр бүлийн хэрэгцээнд суурилж асуудлыг шийдвэрлэх нэгдсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь амжилтыг нэмэгдүүлэх (Jeanne C.Marsh, 2006) үндэс юм. Асрамжийн төвийн хамгийн эхний зорилго бол төрөл бүрийн шалтгаанаар ирсэн хүүхэд өсвөр насныхныг аль болох хурдан хугацаанд, аюулгүйгээр гэр бүлд нь эргэн нэгтгэх учраас гэр бүлийн давуу талд тулгуурлах загвараар тулгамдсан асуудлыг шийдвэрлэх олон талт стратегийг хэрэгжүүлдэг байх ёстой. Хүүхдийг гэр бүл, эцэг эхтэй уулзуулах нь нэг удаагийн арга хэмжээгээр биш олон төрлийн үйлчилгээ, дэмжлэгээр бодит болох юм.

Эргэн нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд гэр бүлийн харилцаа холбоог сэргээх нь чухал бөгөөд энэ нь гэр бүлийн гишүүд болон асран хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтан зэрэг хүмүүсийг багтаасан хамтын ажиллагаа юм.

Гэр бүлийн асуудал хариуцсан агентлаг алба, нэгжээс орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран гэр бүлийг эргэн нэгтгэх төлөвлөгөөг

хэрэгжүүлдэг сайн туршлага олон улсад нэлээд байна. Тухайлбал, гэр бүлийн гишүүдийг олж тогтоосны дараа орон нутгийн засаг захиргаатай хамтран хамгаалах чадварын үнэлгээ хийж, эрсдэлийг хянах ажлыг гүйцэтгэх учиртай. Хүүхдийн ашиг сонирхол нэгд учраас хүүхдийн өнцгөөс нөхцөл байдлыг харж, сонсож, ажиглаж, зан үйлийг нь сайтар ажиглах хэрэгтэй. Жишээ нь хүүхэд төвтэй цагийн хуваарьтай байх, хичээлийн цаг хугацаа, тогтвортой байх хэрэгцээг аажим аажмаар тэнцвэржүүлнэ гэсэн үг юм. Хичээлийн улирал эхлэх, шалгалт өгөх зэрэг тэдний амьдралд тохиолдох чухал үйл явдлуудыг харгалзан ажиллах гэх мэт.

ДҮГНЭЛТ

Монгол улсад хараа хяналтгүй хүүхдүүд хуулинд зааснаар 7 хоногоос 1.6 жил асран хамгаалах төвд амьдрах ёстой ч энэ хугацаа 20 түүнээс дээш жилээр үргэлжилж байна. Хэдийгээр үйл ажиллагаа явуулж буй төвүүд хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, хувь хүний хөгжил зэрэгт анхаарч, хамгаалж байгаа боловч эцэг эх гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг асрах төвүүд дангаараа хэрэгжүүлэх үйлчилгээ биш.

Гэр бүлийн асуудал, архины хамаарал, хүчирхийлэл, үл хайхрал зэрэг асуудлаас хүүхдүүд гэр бүлээсээ тусгаарлагдан төвд амьдарч байгаа ч эцэг эх, гэр

бүлтэй эргэн нэгтгэх үйлчилгээний ирээдүйн үр ашигт анхаарч, орон нутгийн засаг захиргаа, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага, олон нийтийн оролцоо, нөөцийг дайчилж олон улсын сайн туршлага, загваруудаас нутагшуулах хамтын ажиллагаа хэрэгтэй байна. Хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэхийн тулд тэдний гэр бүлийг ч орхигдуулахгүйгээр хэрэгцээг хамтад нь шийдвэрлэх арга зүй илүү үр дүнтэй байгааг бусад улс оронд хэрэгжиж буй хөтөлбөр туршлагаа харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. A. LaBrenz a, R. F. (2019). *The road to reunification: Family- and state system-factors associated with successful reunification for children ages zero-to-five*
2. Berenice Rushovich, K. S. (2021 оны March). *A post-reunification service model: Implementation and population served. Children and Youth Services Review, <https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S0190740921000074>. Volume 122*
3. *Child Welfare Information Gateway. (2011)*
4. Elaine Walton, M. W. (1995). *Intensive Family Reunification Service: A Conceptual Framework and Case Example. . Journal of Family Strengths. Vol.1. Iss.1, Article 6*
5. Germain, C. &. (1988). *The Life Model of Social Work Practice. New York: Columbia University Press*
6. IRR. (2017). *Industrial Robot Report statistics*
7. Jeanne C.Marsh, J. P. (2006). *Integrated services for families with multiple problems: Obstacles to family reunification. Children and Youth Services Review., www.elsevier.com/locate/childyouth*
8. Kurtzweil, R. (2005). *The Singularity is near . USA, Amy Hill*

9. Maslow, A. H. (1973). *A theory of human motivation*. Monterey, CA: Wadsworth Publishing Company
10. Perlman, H. H. (1957). *Social casework*. University of Chicago Press.: Chicago
11. Rabin, C. R. (1982). Home-based marital therapy for multiproblem families. *Journal of Marital and Family Therapy* (4), 451-461
12. Wulczyn, F. (2004). *Family Reunification*. *The Future of Children*
13. <http://www.futureofchildren.org/index.htm>
14. НҮБХС(2003). *Хараа хяналтгүй хүүхэд*. Улаанбаатар.
15. Ц.Амаржаргал, С.Туяа (2025). *Асрамж халажийн төвөөс гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээний сайн туршлага*. Улаанбаатар